

БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭ- ИННОВАЦИЙН БҮТЭЭЛ

А.Энхмаа, дэд.профессор, УБТС

Abstract: The Mongolia National University of Education can prepare skilled and experienced graduates to become creative innovators. This we can prepare valuable human resources for development in our country. This particular article features methodologies to produce a creative thinking, a theoretical basis for studying activity, and entrenching development of creative and innovative habits among students in training practices.

It is very important that students should be able to adopt a creative approach to the processing of information, knowing how to that is logically helpful and usable for their purpose. Students should develop steadily an appreciation of such an attitude because students cannot become creative thinkers suddenly. (17).

Furthermore, such training content can itself be innovative and can become part of social development. Teachers have the opportunity to choose new technological options, to select new production materials and to think creatively about the curriculum.

Proof that students and teachers together have moved forward in processes of creativity and development can be found in the success of such training projects over the last few years.

It is important for our universities and innovation schools to develop special physical innovation centers. This must be part of their policies and plans. Such centers can provide a location for innovators and for departments that engage in innovative activity. They can provide production facilities [as well as providing the facilities to encourage invention, innovation and development].

The promotion and integration of scientific study, innovative activity and implementation of the results of such study and activity requires the adoption by the authorities of a deliberately created system for these purposes.

Түлхүүр үг: Бүтээлч сэтгэлгээний арга зүйн 3 үндсэн чиглэл, философи, нийгэм, сэтгэл зүйн үндэс, бичил төсөл, инновацийн бүтээгдэхүүн

Үзэл баримтлал

Монгол улс боловсролын тогтолцоогоо өөрчлөн шинэчлэхдээ дэлхий нийтийн чиг хандлагын дагуу нийгмийн ба хувь хүний хэрэгцээ шаардлагыг нэн тэргүүнд тавьж сургалтын хөтөлбөр стандартыг боловсронгуй болгох бодлого баримталж байна. Суралцагчдын сонирхол, бүтээлч идэвх, авьяасыг хөгжүүлэх, сургалтын арга, хэлбэр, хэрэглүүрийг оновчтой сонгож, эцсийн дүнд улс, нийгэм шинжлэх ухаан, технологийн хөгжлийн гол чиг хандлагыг урьдчилан харж, шинээр үүсэн гарч байгаа асуудал, нөхцөл байдлыг соргог мэдэрч, өмнөө тавьсан зорилго, зорилтуудыг бүтээлчээр шийдвэрлэж ажиллах, мэдлэгээ баялаг болгох мэргэжилтэн бэлтгэхээр зорьж байна.

Сургалтын онол, арга зүйн ухаан нь суут сэтгэгчид, гарамгай сурган хүмүүжүүлэгчдийн үзэл санаагаар зуун зууныг дамжин, баяжин хөгжсөөр өнөөдрийн сурган хүмүүжүүлэх сэтгэлгээний хөгжлийн шимтэй хөрсийг бүрдүүлсэн байна.

Бидний өмнөх үеийн сурган хүмүүжүүлэгчид бүтээлч сэтгэлгээний арга зүйн асуудлыг 3 үндсэн чиглэлээр судалжээ.

Нэг дэх чиглэлийн төлөөлөгчид болох

эртний Грекийн эрдэмтэд¹ эрдэм сурахад сайн дурын идэвхтэй бие даасан үйл ажиллагаа гол үүрэгтэй гэдгийг өөрсдийн ном зохиол бүтээлдээ² бүх талаас нь гүн гүнзгий үндэслэн тавьжээ. Энэ үеийн эрдэмтдийн бүтээлд хүний сэтгэн бодох чадварыг бүтээлч үйл ажиллагааны явцад амжилттай хөгжүүлж болохыг заагаад, цаашид уг үйл ажиллагаа нь суралцагсдад шинэ мэдлэг олж авахад баяр баясгалан авчирч, идэвхтэй байдал руу хөтөлдөг гэжээ. Энэ үзэл санаа нь дараа үеийн сурган хүмүүжүүлэгчдийн судалгааны ажлын гол тулгуур болж ирсэн гэж үзэж болох юм.

Хоёр дэх чиглэлийн XV-XVI зууны үеийн их сэтгэгчдийн³ бүтээлүүдэд цаашдын хөгжлөө олсон байна. Энэ үед сургуулийн ажлын зохион байгуулалтыг өөрчлөн сайжруулах, сургалтын процессийг бсоловсронгуй болгон суралцагсдад ойртуулах, хичээлээр оюутны сонирхлыг өрнүүлэх, сэтгэн бодох чадварыг бие даан хөгжүүлэхэд онцгой анхаарч, авч үзсэн байдаг (Коменский, 1875, х.25).

1 Сократ,Аристоксен, Платон, Аристотель гэх мэт [17]

2 Эртний Грекийн сэтгэгч Сократ өөрөө ямар нэгэн зохиол бичиж үлдээгээгүй боловч түүний үйл ажилгааны талаар Платон, Ксенофонтагын бүтээлдүүдээс харж болно (Зайцев А. И.,1991.С. 24—28).

3 Я.А.Коменский, Ж.Ж.Руссо, И.Г.Песталоцци, А.Дистерверг г.м..

Гурав дахь чиглэлийн төлөөлөгчид⁴ судалгаа шинжилгээний ажил нь бүтээлчээр суралцах асуудлын нэг зорилго байх ёстой гэж үзэж байлаа (Г.С.Сковороди, Н.И.Новиков, П.Г.Редкин, Р.М.Микельсон, Е.А.Голант, П.Н.Груздев, Б.П.Есипов, И.Г.Огородников, Ю.К.Бабанский, М.Н.Скаткин, Р.Б.Срода, М.П.Кашкин, г.м).

Н.Д.Никандров [8], А.Г.Молибог [7], П.И.Пидкасистый [9], М.У.Пискунов [10] нарын судалгааны ажилд сургалтын үр дүн нь суралцагчийн идэвхтэй бүтээлч үйл ажиллагаа, багш суралцагч хоёрын хоорондын харилцаа зэргээс шалтгаалдаг болохыг харуулсан байна.

С.И.Архангельский "Оюутны бүтээлч үйл ажиллагааны үндсэн зорилт нь хувийн эрэл хайгуул хийх замаар шинжлэх ухааны мэдлэгийг олж авах чадвар олгож, мэдээллийг эзэмших гэсэн сонирхлыг хөгжүүлэх явдал юм" [1] гэжээ.

Швейцарын эрдэмтэн Ж.Пиажегийн оюуны хөгжлийн үйлдлийн онол, Оросын эрдэмтэн Л.С.Выготскийн суралцахуйн үйл ажиллагааны, Л.В.Занков, В.В.Давыдов, Д.Б.Эльконины асуудал дэвшүүлэх сургалтын сэтгэл зүйн онол, Ш.А.Амоношвили Я.А.Пононарев болон бусад эрдэмтдийн туршилтын сургуулиуд дээр хийсэн судалгаа шинжилгээний ажлууд нь суралцагчдын өөрсдийгөө дайчлан, өөрийгөө нээх, сурч танин мэдэх, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд онолын чухал үндэслэл болж байгаа билээ.

Оросын сургалтын онолчид, тухайлбал, М.М.Данилов, Ю.К.Бабанский, В.И.Загвязинский, Н.Н.Скаткин, И.Я.Лернер, М.И.Махмутов, Ю.В.Шаров, Г.И.Шукина, Т.И.Шамова, А.М.Матюшкин, З.Н.Калмыкова, Д.Б.Богоявленская, Ю.А.Карпов зэрэг эрдэмтэд сургалтын процессыг идэвхжүүлэх, оновчтой болгох, асуудал шийдвэрлэх, судалгааны аргуудыг хэрэглэх, суралцагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зэрэг олон чиглэлээр судалсан байдаг (17).

АНУ-ын Ж.Тейлор, Дж.Гилфорд, Е.Торренс, Паул Фритри, Матив Липмэн зэрэг эрдэмтэд болон Олон улсын уншигчдын нийгэмлэг, Хаборт ба умарт Смитийн коллеж, Умард Айвогийн их сургуулийн багш нарын боловсруулсан "Бүтээлч сэтгэлгээ хөгжүүлэх" төслийн үзэл санаа нь "сургалтын үйл явцыг ардчилах замаар суралцагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх явдал" [3] гэж тодорхойлсон.

Суралцагчдад бүтээлч сэтгэлгээг төлөвшүүлэн, хөгжүүлэх асуудалд Л.Шагдарсүрэн, Д.Санжжав, Б.Даваасүрэн, Ц.Няндаг, Л.Жамц, Д.Шагдар,

Н.Бэгз, Б.Жадамба, З.Өлзийхутаг, Д.Ванчигсүрэн, Ч.Лхагважав, З.Мөнхдалай, Ц.Дэмбэрэл, Д.Нямжав, А.Энхмаа зэрэг эрдэмтэд болон Боловсролын хүрээлэн, МУБИС, МУИС-ийн мэргэжлийн дидактикийн сургалт, судалгааны төв, эрдэмтэд, судлаачдын бүтээлд тусгалаа олсон байна.

Бүтээлч сэтгэлгээ нь агуулга, хэлбэрийн хувьд практик үйл ажиллагаатай салшгүй холбоотой билээ. Өөрөөр хэлбэл, практик, сэтгэлгээ, мэдлэг нь бүтээлчээр сэтгэх үйл явцын чухал элементүүд.

Бүтээлч сэтгэлгээний түүхэн ач холбогдол нь аливаа сэдвээс гадуур, суралцагчдын оюун бодлын ухамсрын хэмжүүрүүдийн үндсэн элементүүдийг тусгасан ойлголтуудыг задлах чадвартай байх ёстой гэж үздэгт оршино.

Мэдлэг бий болон хөгжих үйл явц нь сэтгэлгээний тусламжтайгаар хэрэгждэг. Иймд сэтгэлгээ нь түүний уг чанар болсон практик үйл ажиллагааны салшгүй элемент. Нөгөө талаас авч үзэхэд, сэтгэлгээ нь практик үйл ажиллагааны элемент байгаад зогсохгүй бодит байдлын тусгал юм. Гадаад ертөнцтэй харьцах практик үйлийн явцад ойлголт, оюун дүгнэлт, категори, анализ, синтез зэрэг сэтгэхүйн хэлбэрүүд бий болжээ.

"Бүтээлч сэтгэлгээний мөн чанар нь танин мэдэгч хүн категори хэлбэрээр урьдын хуримтлуулсан мэдлэгт үндэслэн тэдгээрийн хооронд буй холбоог шууд сэтгэн урьдчилан харж хуучин мэдээгүй байсан шинэ мэдлэг олж авдагт оршдог байна" [16].

Ардчилсан нийгэм хөгжихийн хэрээр залуучууд бие даан бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх, нөхцөл байдалд шүүмжлэлтэйгээр дүн шинжилгээ хийх, альтернатив саналыг тунгаан бодох, ухаалаг, өргөн цар хүрээтэй шийдвэр гаргах чадвартай байх нь улам чухал болж байна. Энэ нь бүтээлч сэтгэлгээний нийгмийн үндэс юм.

Суралцагчид аливаа мэдээлэлд бүтээлчээр хандаж, хэрэгцээтэй, баталгаат мэдээллийг оновчтой сонгох чадвартай байх нь маш чухал юм. Үүний тулд сэтгэлгээний зохих чадваруудыг эзэмшсэн байх шаардлагатай. Харин суралцагчид гэнэт бүтээлчээр сэтгэгчид болдоггүй (17).

Хүний эзэмшсэн боловсрол үеийн үед залгамжлагдан хөгжиж, өргөжиж байдаг бөгөөд тухайн нийгэмд оршин амьдрахад шаардагдах чанартай мэдлэг, чадвар нь уг хүний үнэт зүйлс болж байдаг жамтай. Хүн хэдий чинээ хэмжээний мэдлэг, чадвар эзэмшинэ төдий хэмжээгээр өөрт нь оюуны хөрөнгө, үнэт зүйлс хуримтлагдан, нийгэмд баялаг бүтээх боломжийг бүрдүүлж байдаг.

Бүтээлч сэтгэлгээний сэтгэл зүйн үндсийг судалбал ХХ зууны дундуур Америкийн сэтгэл зүйч Гилфорд: "Бүтээлч сэтгэлгээ нь сэтгэл зүйн судлалын хүрээнд хамаардаг бусад ухагдахуунтай харьцуулахад удаан хугацаагаар хэрэгсэхгүй орхигдож байснаа гэнэт идэвхтэй судлагдах болсон цорын ганц судлагдахуун юм" гэжээ [2].

Л.С.Выготский, С.Л.Рубенштейн нарын бүтээлч сэтгэлгээний талаарх санааг Ю.А.Карпов нэгтгэн дараах байдлаар томъёолжээ. "Бүтээлч сэтгэлгээний үр дүн нь материаллаг үнэт зүйлийг бүтээснээр бус, харин хүний сэтгэлгээнд шинэ санаа бий болж шинэ бүтээл туурвих, түүний дотоод ертөнцийг хувирган өөрчлөхөд оршино"[14].

"Үйл ажиллагааны болон бие хүний дотоод ертөнцийн субъектийн өөрчлөлт нь шинэ бүтээл, шинэ санаа бий болох, хөгжих зайлшгүй нөхцөл болдог" [2].

Дж.Джонсон: "Ямар нэгэн шинэ юм бүтээхийн тулд орчноо өөрчлөөд зогсохгүй өөрийгөө болон юмсыг хүлээн авах арга барилаа, магадгүй бодит байдлыг ч бага зэргээр өөрчлөх хэрэгтэй". Өөрөөр хэлбэл, "Ямар нэгэн шинэ зүйл бүтээхэд, өөрийнхөө дотоод ертөнцийг өөрчлөхөд амаргүй байдаг. Тухайлбал, тогтсон байдлаа өөрчлөн сэтгэх, зан үйлийн нэгэн хэм болон хариу үйлдлийн арга барилаасаа татгалзах, үйл явцын дунд шинэ зорилт тавьж, утгын холбоог тэлж өргөсгөх, өөрчлөх, хэрэглэгч, уншигч, сонсогчийн байр сууринаас асуудлыг харж сурах гэх мэт" гэжээ.

"Бүтээлч сэтгэлгээ бол хүний идэвхтэй, бие даасан үйл ажиллагааны дээд хэлбэр мөн", *(Зөвлөлтийн сурган хүмүүжүүлэх ухааны нэвтэрхий толь, 1968 он)*.

Харин сэтгэл зүйн толь бичигт "Бүтээл гэдэг нь материаллаг болон оюун санааны үнэт зүйлийг бий болгодог үйл ажиллагааг хэлнэ" гэжээ

Бүтээлч сэтгэлгээ болон бүтээл нь үзэл бодлын маш өргөн хүрээнд тодорхойлогддог. В.М.Бехтеревынхаар бол хүний рефлексийн байр сууринаас бүтээлийг авч үзээд аливаа асуудлыг шийдэхэд хангалттай туршлага, мэдлэг байгаа нөхцөлд "ямар нэгэн шинэ юмыг бүтээнэ" [2] гэж үзсэн.

А.М.Матюшкин, 3.Н.Калмыкова, Д.Б.Богоявленская нар бүтээлч сэтгэлгээг хүнд өөрт нь байгаа мэдлэгээс давж гарсан зүйл гэж тодорхойлсон. Я.А.Пономарёв "Хамгийн өргөн утгаараа бүтээлч сэтгэлгээ нь хөгжил дэвшилд хүргэх зүй тогтолцоо гэж ойлгож байна" гэжээ.

Сэтгэл зүйчид "Бүтээлч сэтгэлгээг" судлах

үндсэн чиглэлүүдийг дараах байдлаар тодорхойлж байна.

Нэгдүгээрт: Бүтээлч сэтгэлгээг бүтээлийн үр дүнгээр судалж болно. /Ж.Тейлор/ өөрөөр хэлбэл, тоо ширхэг, чанар, ач холбогдлоор нь гэх мэт. Гэхдээ зарим судлаачид "үр дүн болох бүтээгдэхүүн" нь хүний бүтээлийн цорын ганц хэмжүүр байж болохгүй гэж үздэгийг дурьдах нь зүйтэй.

Хоёрдугаарт: Бүтээлч сэтгэлгээ нь хүнд тогтсон нэг хэмийн сэтгэх арга барилаас татгалзах чадвар гэж үздэг. (Дж.Гилфорд, Е.Торренс).

Олонх судлаачид бүтээлч сэтгэлгээг (Блум АНУ-ын) танин мэдэхүйн ангилалын дээд шатлалд хамааруулан үздэг байна. Паул Фритри (1970, АНУ) Бүтээлч сэтгэлгээ гэдгийг ухаан, ухамсар сэргээх, хөгжүүлэх гэсэн ойлголтод хамааруулан авч үзжээ.

Философч Матив Липмэн (1991) танин мэдэх бүтээлч сэтгэлгээ гэдгийг оновчтой тодорхойлох гэсэн бүх оролдлогын жагсаалт хийж үзээд "Ийм жагсаалт эцэс төгсгөлгүй. Учир нь хүн төрөлхтний оюун ухааны хүчин чадал хязгааргүй юм" [3] гэжээ.

Оюутныг хөгжүүлэхэд тэдний нас, сэтгэл зүй, хэрэгцээ, сонирхол, үйл ажиллагааны чадвар зэргийг онцлон харгалзаж, сурах хүсэл, тэмүүллийг өдөөн, багш оюутны харилцан идэвхтэй үйл ажиллагаанд оруулж, бүтээлч бодол санаа, сэтгэлгээ урган гарч, өөрсдийн мэдсэн зүйлдээ тулгуурлан шинийг хийх, санаагаа илэрхийлэхүйцээр сургалтыг зохион байгуулах нь бүтээлч сэтгэлгээ хөгжүүлэх арга зүйн сэтгэл зүйн үндэс болно" [12]

Мэдлэг эзэмшинэ гэдэг бол бусдын туршлагын үр дүнг хувийн туршлагын үзүүлэлттэй нийлүүлнэ гэсэн үг юм. Иймд хувийн туршлагыг бий болгох эх үндэс болсон тэдний бүтээлч үйл ажиллагаа "бусдын туршлагыг эзэмших" [11] үед ч чухал байдаг байна.

Бүтээлч сэтгэлгээний дидактик үндсийг авч үзэхэд суралцах үйл ажиллагааг үр ашигтай зохион байгуулж удирдахад суралцах үйл ажиллагааны Л.С.Выготскийн онолын зарчим гол тулгуур болно. Түүний онолоор бол суралцагч аливаа юмс үзэгдлийг хэрхэн таньж, шинэ мэдлэгийг хэрхэн өөрийн болгодог зүй тогтлыг танин мэдэхүйн сэтгэл зүйн ухаан судлан илрүүлжээ. Хүний учир шалтгаант нарийн нийлмэл үйл ажиллагаа нь байгаль, нийгмийн орчны (мэдээлэл, соёлын) шууд нөлөөгөөр үүсэн хөгжиж байдаг учраас үйл ажиллагаа нь зорилгын дотоод мөн чанартай, аливаа хүн орчиндоо дасан зохицох, эсвэл

яваандаа энэ орчинтойгоо ондоошин өөрчлөгдөх үйл явцыг илэрхийлдэг бөгөөд орчинд дасан зохицох 2 хэлбэртэй ажээ. Энэ нь:

- Хүн өөртөө буй боломжийн хэрээр орчноо хувирган зохицох- ассимляц.
- Хүн өөрөө өөрчлөгдөж орчиндоо дасан зохицох-аккомодаци.

Суралцах сургах гэсэн хоёр талт үйл явцын нэгдэл болсон сургалт бол хүн нийгмийн түүхэн хөгжлийн явцад аливаа шинэчлэл, хөгжил, дэвшлийн эх сурвалж болсоор ирсэн билээ. Ийм ч учраас шинэчлэгдэн дэвшиж буй даяаршлын өнөөгийн нийгэм сургалтыг ямагт оновчтой, шинэлэг байхыг шаардах боллоо. Сургалтын явцыг боловсронгуй бүтээлч, үр дүнтэй болгох асуудал юуны өмнө сургалтад оролцогч хүнээ зөв танин мэдэж, түүнд нийцсэн сургалтыг нийгмийн хэрэгцээ, шаардлагын дагуу явуулж байгаа эсэхээс хамаардаг.

Сургалтын арга технологийн дидактик онолын үндэслэлд нэлээд олон урсгал чиглэлийг хамруулж болох юм. Сургалт, хөгжлийн диалектик холбоог тайлбарлахдаа нэг хэсэг онол нь сургалт хөгжлийг шийдвэрлэнэ гэж үзээд бие зүйн өсөлт, гарваль төрөлх чанар хөгжилд ямарч нөлөөгүй гэж үздэг. Жишээ нь: Английн эрдэмтэн Ф.Бэкон: "Хүн төрсөн үедээ, дээр нь бичиж, цоохорлож болох цэвэр самбар" хэмээн үзэж байсан явдал юм. Нөгөө чиглэл нь сургалтаас хөгжил шалтгаалахгүй, харин төрөлх гарваль шинж, бие зүйн өсөлтөөр тодорхойлогдоно" гэж үздэг.

Өнөөгийн сургалтыг суралцагчдын оюун сэтгэхүй, авъяас чадвар хувийн туршлагад шууд тулгуурлан, тэд өөрсдөө жинхэнэ ёсоор хөгжиж, тодорхой бүтээл шийдэл гаргаж байх, багш-оюутан, оюутан-оюутан, оюутан-багш, оюутан-өөртэйгээ, оюутан-нийгэмтэй харилцах харилцааг ардчилсан үзэл санаанд зохицуулах шаардлага гарч байна. Сургалтыг шинжлэх ухааны үндэстэй удирдан хөтлөх, сургах зүйн тогтолцооны ерөнхий онол, сурах, сургах үйл' явц, багш шавийн

харилцаа, сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтыг судалгаатай холбон авч үзэхийг хичээж цаашдын судалгаа туршилтыг явуулав.

Урлаг биеийн тамирын сургуульд багш, оюутнуудын сургалт судалгааны ажилд бүтээлч сэтгэлгээ, шинэ санаа, инновацийн бүтээл бий болгох бодлого баримтлан "урт", "богино" хугацааны төсөл бүхий хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, туршив. Богино хугацааны бичил төсөлд технологийн бодлогууд дараах өгөгдөлтэй байсан ба гүйцэтгэх хугацааг 1 семестрээр тооцож дахин сайжруулан боловсронгуй болгосоор 2 жил ажиглав. Үүнд:

1. "Сургалтын хэрэглэгдэхүүн"
2. МУБИС-ийн "Цаг төлөвлөх календарь" төсөл
3. "Үзүүлэн" төсөл
4. "Плакат", "Гэрэл зураг"
5. "Уран зураг" төсөл
6. "Ноос, ноолууран ороолт" сүлжмэл эдлэл төсөл
7. "Хантааз" Монгол хувцас төсөл
8. МУБИС бэлэг дурсгал төсөл
9. 3D загвар зохон бүтээлт төсөл гэх мэт

Дээрх төслүүд бүгд амжилттай хэрэгжсэн хийгээд оюутан, багш хөтөлбөрөө бүтээлчээр судлах улмаар хичээл үйлдвэрлэлээр хийх эдлэлийн загвар дизайн, технологийн зохистой сонголтыг уян хатан хийх, гарсан бүтээгдэхүүнүүдийг үргэлж шинэчилж, инновацлаг шинжийг тусгах, нийгмийн дэвшлээс хоцрохгүй байх зарчим баримтлав.

"МУБИС-ийн бэлэг дурсгал" бичил төслөөр олон загварууд хийсэн бөгөөд нэгэн ажилд гарсан ахиц өөрчлөлтийг харьцуулбал:

МУБИС-ийн бэлэг дурсгал болох энэхүү аягыг (зур.1) хятад улсад үйлдвэрлэсэн ба лого шошгыг нийтийн үйлчилгээний газраар наалгасан, 2014 он.

Үзэгний савыг (зур. 2,3) багш оюутнууд сургалтаар үйлдвэрлэж улам сайжруулсан оюуны бүтээл, керамик технологи сургалтад нэвтэрсэн, инновацийн бүтээгдэхүүн. 2015, 2016 он.

"МУБИС бэлэг дурсгал" төсөл

	2015 он	2016 он
 2014 он Инновацийн бус бүтээгдэхүүн	 2015 он Багш оюутны бүтээлч хөдөлмөр шингэсэн бүтээгдэхүүн	 2016 он Багш оюутны бүтээлч сэтгэлгээ, мэдлэг шингэсэн бүтээгдэхүүн

Төслийн туршилт сургалтын явцад багш, оюутнууд бүтээлчээр хамтран ажиллаж инновацийн бүтээлүүд боловсруулсан нь бүтээлч сэтгэлгээний илрэл юм. Нөгөө талаас бүтээлч сэтгэлгээ төлөвшүүлэх бие даасан үйл ажиллагааг “Оролт буюу оюуны -шинэ санаа, шинжлэх ухааны үр дүн-гаралт буюу чансаат бүтээгдэхүүн” гэж үзэж болох ба бүтээлч сэтгэлгээтэй иргэн бий болоход чухал алхам болох юм.

ДҮГНЭЛТ

ШУ-ны судалгаа-сургалт хөгжиж багш, оюутнууд хамтын эрэл хайгуулалтад татагдан орох, бие биенээсээ сэдэл авах, суралцах, тэдний бүтээлч сэтгэлгээ бүтээлд хэрхэн илэрч байгааг санаачилан хэрэгжүүлсэн төслийн бодит үр дүнгээр илрүүлэхийг онцоллоо.

Оюутнууд мэдлэгээ бүтээх таатай орчныг бүрдүүлэх, бие дааж амьдарч, сурч боловсрох гэсэн ойлголтод тулгуурласан судалгаа шинжилгээ, практик үйл ажиллагааны загварыг боловсруулах, судалгаа шинжилгээнд тулгуурласан үйл ажиллагаанд суурилах, үйл ажиллагааны ерөнхий зарчмаас урган гарсан онол практикийн төрөл бүрийн шатны сургуулийн янз бүрийн чиглэлийн сургалтын тохиромжтой үйл ажиллагаанд татан оролцуулах, хянаж удирдах боломжийг багшид олгох гэх мэт бие даасан бүтээлч ажиллагаа нь тасралтгүй байвал нь илүү үр дүнтэй.

Ингэснээр танин мэдэх үйл ажиллагааг идэвхжүүлэх, бүтээлч үйл ажиллагааг хөгжүүлэх, мэргэжлийн сонирхол төрүүлэх, бүтээлч сэтгэлгээг төлөвшүүлэх ач холбогдолтой.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Архангельский, С.И. (1980). *Учебный процесс в высшей школе, его закономерные основы и методы*. Москва

Головей, Л.А. (2001). *Практикум по возрастной психологии*. Санкт-Петербург

Жеани, Л. (2000). Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх төсөл товхимол. 1-9. Улаанбаатар

Jean L (2000). *Critical thinking*. Монгол Улсын ШУТ-ийн тухай хууль. (2008). Улаанбаатар

Матюшкин, А.М. (1975). *Актуальные проблемы психологии в высшей школе*. Москва

Молибог, А.Г. (1987). *Организация и планирование педагогической работы высшей школе*. Москва

Никандров, В.Д. (1978). *Современная высшая школа в капиталистических стран*. Москва

Пидкасистый, П.И. (1980). *Самостоятельная познавательная деятельность школьников в обучении*. Москва

Пискунов, М.У. (1982) *Организация учебного труда студентов*. Минск

Сеченов, И.М. (1952). *Избранные произведения* Т1. Москва

Чанартай боловсрол хөгжлийн баталгаа илтгэлүүдийн эмхэтгэл. (2001). Улаанбаатар

Чернилевский, Д.В (2002). *Дидактические технологии в высшей школе*. Москва

Фохин, Ю.Г. (2002). *Преподавание и воспитание в высшей школе*. Москва

Хатантөмөр. (1985). *Бүтээлч сэтгэхүй*. Улаанбаатар

Эльконин, Д.Б. (1971). *К проблеме перлюдизаций психического развития в детском возрасте. Вопрос психологии*. Москва

Энхмаа, А. Оюутанд бүтээлч сэтгэлгээ төлөвшүүлэх нь. докторын диссертаци, (2002).

[http://www.scribd.com/doc/85467686/
www.eri.mn/index.php/mn/l?task=view&catid](http://www.scribd.com/doc/85467686/www.eri.mn/index.php/mn/l?task=view&catid)